МОНГОЛ ТУВАГИЙН ХАРИЛЦААНЫ ХАМГИЙН ЭМЗЭГ АСУУДАЛ-ТУСГААР ТОГТНОЛ, ХИЛ ХЯЗГААР

Дорж овогтой Шүрхүү 1963 онд төрсөн, 1970-1980 онд бага дунд сургууль, 1980-1985 онд МУИС–ийг дүүргэсэн. 1985 оноос ШУА–ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн Хятад судлалын секторт эрдэм шинжилгээний туслах ажилтнаар ажилласан. Одоо ШУА–ийн Олон улс судлалын хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

-Өнгөрсөн оны 12-р сард "Монгол Тувагийн харилцаа, Орос улсын байр суурь" (XX зууны эхэн хагас) сэдвээр түүхийн ухааны дэд докторын зэрэг амжилттай хамгаалсанд Танд баяр хүргэе. Яагаад энэ сэдвийг сонгон эрдмийн ажлаа хийх болов оо? Таны зэрэг хамгаалсан бүтээл чинь энэ чиглэлийн бусад судалгаанаас ямар онцлог давуу талтай вэ?

-Баярлалаа. 1910-20-иод оны үеийн Монгол орны дотоод, гадаад улс төрийн амьдралд, ялангуяа Монгол-Оросын харилцаанд Тагна Тува буюу Урианхайн хязгаар их нөлөө үзүүлж байсан нь түүхэн баримтуудаас тодорхой харагддаг. Гэвч өнөөг хүртэл энэ чиглэлээр дорвитой судалгаа хийгдээгүй байлаа. Мөн Монгол улс Туватай 1926 оноос 1944 он хүртэл бие даасан улсын хэмжээнд харилцаж байсан түүх ч төдийлөн судлагдалгүй орхигдсон юм. Ер нь Тува нарын угсаа гарал, түүх болон улс төр эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх үнэн зөв мэдээлэл ихээхэн үгүйлэгдэж байна. Харамсалтай нь манай зарим сонин хэвлэлд Монгол-Тувагийн харилцааны түүхийн талаарх зарим үйл явдлыг таамгаар, дам сургаар бичсэн алдаатай материалууд гарсаар байна. Тухайлбал саяхан Монгол-Тувагийн хил дээр болсон эмгэнэлт явдлын халуун мөрөөр сэтгүүлч Ш.Цэрэнпил "Өдрийн сонин"-ы 2000 оны №28 дугаарт бичсэн нэгэн өгүүлэлдээ "Манай улс Тувагийн өөртөө засан тохинох эрхийг 1924 он хүртэл хүлээн зөвшөөрсөн, Данзан-Оол гэгч 1921 онд Х.Магсаржавт төрийн хүлээн авалт дээр буу тулган агсамнаж байсан" тухай дурьдржээ. Гэтэл Монгол улс 1924 онд биш 1926 онд Тагна Тувагийн засгийн

газрыг хүлээн зөвшөөрсөн билээ. Хатанбаатар Магсаржав ч 1921 онд дөнгөж байгуулагдаж байсан Тувад очиж төрийн хүлээн авалтад оролцож байгаагүй, харин 1924 онд Тувагийн Хэмчигт гарсан бослогын үеэр тэндэхийн зарим хошуудаас Монгол улсад дагаар орох хүсэлт гарсан хэрэг явдлыг Зөвлөлтийн төлөөлөгчидтэй хэлэлцэхээр очих үед нэг тийм явдал болсон юм. Энэ мэтээр баримт нотолгоо судалгаагүйгээр түүхэн үйл явдлыг тоймлон бичиж болохгүй бөгөөд тэр тусмаа харилцаа тийм ч сайнгүй байгаа Тува нарын тухай буруу зөрүү зүйл олонтаа гарвал цаашдаа улс хоорондын харилцаанд ч нөлөөлж болох талтайг эрхэм сэтгүүлч, нийтлэлч нар анхаарах хэрэгтэй болов уу. Энэ бүхэн дээрх сэдвээр дорвитой судалгаа хийх нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Би анх 1994 онд Тувагийн Хэл зохиол, түүхийн хүрээлэнгийн урилгаар Кызылд очиход тэндхийн хүн ард Монгол улсын түүх, ардчилал, шинэчлэлийн үйл явц, өнөөгийн байдлыг асар их сонирхож буй нь илт мэдрэгдэж байсан бөгөөд Монголын тухай мэдээлэл маш хомс байдаг тухай бараг уулзсан хүн болгон ярьж байлаа.

Үүнээс гадна тухайн судалгааг хийх улс төрийн аятай таатай нөхцөл бололцоо бүрдсэнийг дурьдах хэрэгтэй. 1921 оны Монгол-Оросын хэлэлцээр дээр Тагна Туваг Монголын бүрэлдэхүүнд оруулах асуудлыг монголын төлөөлөгчид сөхөн тавьж байсан тухай, Монгол-Тувагийн хилийн асуудал хэрхэн шийдэгдсэн тухай зэрэг асуудлыг 1990 оноос өмнө бичих нь байтугай ярихад ч хориотой сэдэв байлаа. Судалгаа явуулахад нааштайгаар нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл бол судлаачид урьд хаалттай байсан архивын материалтай танилцах боломжтой болсон явдал юм.

1990-ээд оны эхээр манай хүрээлэн хөрш орнуудад аж төрөн сууж буй монгол угсаатгны түүх, засаг захиргаа, өнөөгийн байдлын тухай нэлээд томоохон төсөл хэрэгжүүлсэн бөгөөд үүний үр дүнд "Орос дахь Монгол угсаатны улсууд" /УБ, 1995/, "Хятад дахь Монголчууд" /УБ, 1996/, "ОХУ-ын БНБуриад улс" /УБ, 1996/ зэрэг ном товхимолууд гарсан юм. Миний судалгаа бол үүний үргэлжлэл гэж хэлж болно. Энэхүү судалгааны гол онцлог болон давуу тал гэвэл Монгол-Тувагийн харилцааны асуудлыг цогц байдлаар авч үзсэн дотоод гадаадын архивын шинэ материалуудыг ашигласан явдал юм.

-Монгол-Тувагийн харилцааны талаар ярилцахаас өмнө та тува нарын угсаа гарал, засаг захиргааны талаар жаахан тодруулахгүй юу. Мөн туунчлэн яагаад Туваг Тагна Урианхай, Урианхайн хязгаар, Тагна Тува, Тыва гэх мэтээр олон янзаар нэрлэдэг юм бэ?

-Тувагийн тухай ярих бүрд эдгээр асуултууд зүй ёсоор гарч

ирдэг. Тийм ч учраас би диссертацийнхаа эхэнд энэ тухай товч дурьдсан юм. 1964 онд Москвад хэвлэгдсэн "Тувагийн түүх"-ийн хоёр ботид тува нарын дээд өвөг хүннүгээс гаралтай байж болохыг хүлээн зөвшөөрсөний сацуу Алтай, Саяны уулсаар нутаглаж байсан "тэлэнгэд", "теле"аймгуудаас одоогийн тува нар үүсэлтэй хэмээн бичсэн байдаг. Мөнхүү зохиолд тува нар бол түрэг угсааны бие даасан үндэстэн бөгөөд монголын феодалууд болон манжийн захиргаанд олон зуун жил дарлагдаж явсан хэмээн дурьджээ. Гэвч уг түүх зохиогдсоноос хойшхи 30 гаруй жилийн дотор нэлээд их зүйл өөрчлөгдсөн тул хөрөнгө мөнгөний улмаас хэвлэлт нь хүлээгдэж буй шинэ түүхэндээ тувагийн эрдэмтэд ямар ямар өөрчлөлт оруулсан нь ихээхэн сонирхол татаж байна.

Манай ихэнхи түүхчид тува буюу тагна урианхай нар бол түрэг болон монгол овог аймгууд Саяны нуруу Тагна уулын хооронд олон зуун жил хольцолдон аж төрөх явцад бүрэлдэн, өөрийн өвөрмөц хэл соёл, ахуй байдлаа өнөөг хүртэл хадгалан ирсэн үндэстэн хэмээн үздэг. Эрдэмтдийн тооцоолсноор тува хэлний үгсийн сангийн 30 орчим хувийг монгол гаралтай үгс эзэлдэг ажээ. Дашрамд хэлэхэд тува нар 1931 онд зөвлөлтийн эрдэмтдийн оролцоотойгоор өөрсдийн бичиг үсгээ зохиох хүртэл монгол бичиг хэрэглэж байсан юм. Ер нь тэднийг цэвэр түрэг угсааны, эсвэл цэвэр монгол угсааны хэмээн аль нэг тал руу туйлшруулан тодорхойлох нь төдийлөн оновчтой биш.

Улсын төв номын санд хадгалагдаж буй "Тагна Урианхайн уг эхийн товчоон" хэмээх гар бичмэлд тэмдэглэснээр манж нар Хотгойдын шадар ван Чингүнжав манжийн төрд тэрслэн боссоны учир түүний захиргаанд байсан Тагна Урианхай ба Хөвсгөл Урианхайн 16 отгийг Тэс голын (хожим Ойнар хошуу болсон), Хэм голын(Салчиг), Тож нуурын, Хөвсгөлийн гэсэн 4 хошуу болгон өөрчлөөд Улиастайн манж жанжинд захируулжээ. Үүний дараа Хэмчиг, Бэйс, Маады, Шалык, Сартуул гэсэн 5 хошууг нэмэн байгуулсан юм. Хошуудыг бүгдийн дарга захирах бөгөөд тэднээс нэгийг нь Тагна Урианхайг ерөнхийлөн захирах амбан ноёноор сонгон томилохоор шийдвэрлэжээ. Эхний үед тува нарын дундаас тэнцэх хүн гараагүй тул 1763-1786 онуудад халхын ноёд Тагна Урианхайн амбанаар томилогдсон юм. 1786 оноос Урианхайн тэргүүлэгч, зайсан Хурулмайн хүү Ойнар хошуу залгамжлан амбан ноён суужээ. Гагцхүү 1915-1916 онд оросуудын дэмжлэгтэйгээр баян Агваандэмчиг амбаны тушаалыг хүчээр булаан авсан боловч удалгүй бусдад хорлогдсон байдаг. Гэхдээ Тагна Урианхайн амбан ноён дээр дурьдсан бүх 9 хошуугаа захирч байсангүй. Бэйс, Маады, Шалык, Сартуул хошууд монгол ноёдын

захиргаанд байсан бөгөөд 1878 онд Хөвсгөлийн буюу Хасуд хошуу, 1900 онд Хэмчиг буюу Даа хошуу амбаны захиргаанаас гарсны дараа амбан Гомбодоржийн мэдэлд зөвхөн Ойнар, Салчиг, Тож гурван хошуу үлдсэн байв.

Урианхай, тува гэдэг нэрсийн уг гарал, хоорондын холбоо хамаарал болон судлаачдын сонирхлыг ихээхэн татаж буй асуудал юм. Тувагийн түүхчдийн бичсэнээр урианхай гэдэг бол тува нарын язгуурын нэр биш гагцхүү манж, монгол сурвалж бичигт тэднийг Тагна Урианхай хэмээн нэрлэдэг бол оросууд Урианхайн хязгаар, мөн соёдууд ч гэж нэрлэсэн ажээ. Харин 1921 онд Тува нар бие даасан улсаа байгуулах үед дээрх нэрүүдээс татгалзан өөрсдийгөө Тагна Тува хэмээн нэрлэхээр шийдвэрлэжээ. 1991 оноос тува нар улсынхаа нэрийг ОХУ-ын Бүгд Найрамдах Тыва Улс болгон өөрчилсөн юм. Энэ нь тува хэлний дуудлагад тохируулсан өөрчлөлт байж болох бөгөөд монгол бичигт ч "тува" биш "тыва", "тива" гэж бичдэг.

-Монгол-Тувагийн харилцааны гол гол үйл явдлуудаас тоймлон яривал. . .

-2дугаар үед хамааруулж буй 1921-1925 онуудад ардын хувьсгалаар гарч ирсэн Монголын шинэ засгийн газар өмнөх Богдын засгийн газрын монгол туургатны нэгдсэн улс байгуулах зорилго бүхий чиг баримтлалыг үргэлжлүүлж, Урианхайн хязгаарыг өөртөө нэгтгэх талаар идэвхитэй бодлого явуулж байлаа.

Бүр хувьсгалд бэлтгэж байх үед ч монголын хувьсгалчид 1915 оны гурван этгээдийн Хиагтын гэрээ ёсоор Тагна Урианхай шинэ Монгол улсын бүрэлдэхүүнд орох ёстой гэж үзэж байсан нь архивын материалаас тодорхой харагддаг. Тийм ч учраас Ардын түр засгийн газрыг байгуулахдаа Урианхайн хязгаарт зориулан нэг орон тоо үлдээж, Д.Чагдаржавыг тийш нь томилон илгээснээс гадна, монголын хувьсгалчид засгийн эрхийг авахаас өмнө зөвлөлтийн удирдлагатай хийж байсан яриа хэлэлцээний үеэр урианхайн асуудлыг удаа дараа сөхөн тавьж байж.

Монгол ардын хувьсгал ялсны дараахан 1921 оны 8 дугаар сард оросуудын идэвхитэй оролцоотой зохион байгуулсан бүх тувагийн их хурлаас Бүгд Найрамдах Тагна Тува улс байгуулах шийдвэр гаргажээ. Энэ Тувагийн түүхэн дэх хамгийн анхны бие даасан улс болсон юм.

Энэ үйл явдлаас хэдхэн сарын дараа 1921 оны 11 дүгээр сард Москва хотноо болсон Монгол Зөвлөлтийн найрамдлын гэрээ байгуулах хэлэлцээн дээр монголын тал "Урианхайн хязгаар Монголын ардын засгийн газрын захиргаанд байна" гэсэн заалт Гэрээнд оруулах

санал тавьсан нь хэлэлцээг бараг тасалдуулах шахсан бөгөөд Зөвлөлтийн төлөөлөгчид урианхайн ард түмэн өөрсдөө хувь заяагаа тодорхойлох ёстой хэмээн уг саналыг эрс няцааж байв. Монголын төлөөлөгчдийн тэргүүн С.Данзан урианхай нар Монголын захиргаанд байх үндэслэлийг үндэс угсаа, шашин шүтлэг, засаг захиргаа, түүхэн уламжлалын үүднээс ул суурьтай учирлан тайлбарласан боловч Зөвлөлтийн талын байр суурийг өөрчилж чадаагүй. Гэхдээ хэлэлцээрийн протоколоос үзэхэд Зөвлөлтийн тал Урианхайн хязгаарыг хойшид өөрийн нутаг хэмээн үзэхгүй гэх мэт зарим нэг заалтыг оруулахыг зөвшөөрч байжээ. Харин С.Данзанд хэлэлцээ хийх туршлага, дипломатын арга ухаан дутсаны улмаас асуудлыг бүр мөсөн шийдэхийг махран зүтгэж, бага ч гэсэн нааштай боломжийг ашиглаж чадаагүй бололтой. Хоёр тал урианхайн асуудлыг хожим жич шийдвэрлэхээр тогтжээ.

1924 оны хавар Хэмчигийн хошуудад гарсан бослогын үеэр Тувагийн зарим хошуудаас Монгол улсад дагаар орох болон оросын талыг баримталсан засгийн газрын хүчирхийллээс авран хамгаалах талаар Ховдын сайдаар уламжлан манай засгийн газарт удаа дараа хүсэлт тавьсан явдал Монгол-Зөвлөлтийн харилцааг ихэд хурцатгасан юм. Монголын Засгийн газар энэхүү бослого нь Тувад сууж буй Зөвлөлтийн консул сайд болон тэндэхийн орос иргэдийн зүй бус ажиллагаатай холбоотой хэмээн үзэж байхад Зөвлөлтийн тал урианхайн асуудлыг өөртөө ашигтайгаар шийдвэрлэхийн тулд монголын зүгээс хийсэн ээлжит далд явуулга хэмээн таамаглаж байв. 1924 оны 5 дугаар сард Монголын Засгийн Газраас Зөвлөлтийн талд хоёр ч удаа ноот гардуулсан нь байдлыг улам хурцатгасан бөгөөд Зөвлөлтийн Засгийн газар Тувад цэргээ оруулан Монголын эрх баригчдад цэрэг, улс төрийн хүчтэй даралт шахалт үзүүлсэн юм. Гэвч хоёр тал хэрэг явдлыг хэлэлцээний замаар шийдэхээр тохиролцон бүрэн эрхт төлөөлөгчдөө Кызыл рүү илгээжээ. Монголын Засгийн Газрын эрх барих төлөөлөгч Цэргийн сайд Х.Магсаржав, Зөвлөлтийн Засгийн Газраас томилогдсон эрх барих төлөөлөгч Х.Давтян нар 1924 оны 8 дугаар сард Кызыл хотноо хэлэлцээ хийж, бослого гарсан нөхцөл шалтгааныг сайтар нягтлан шалгаад, сөргөлдөгч талуудын зэвсгийг хурааж, Тувад амгалан тайван байдал тогтоохоор хэлэлцэн тохирчээ. Монголтой нэгдэх хүсэлтийн хувьд Тувагийн цаашдын хувь заяаг ард олны чин хүсэл саналыг харгалзан Монгол, Зөвлөлтийн засгийн газрууд жич шийдвэрлэх тул уг асуудлыг түр хойшлуулахаар болжээ.

1925 оны эхээр дээрх хэлэлцээнд заасан ёсоор Тувагийн бараг

бүх хошуудаас Монгол улстай нэгдэх хүсэлтээ Тувагийн Ардын Хувьсгалт Нам, Засгийн газраараа дамжуулан ирүүлсэн ажээ. Энэ үе бол Монгол Тува хоёр нэгдэх хамгийн тохиромжтой үе байсан боловч нөхцөл байдал эсрэгээр өрнөсөн юм.

-Тувагаас ирүүлж байсан тэрхүү хүсэлтүүд манайд одоо бий юу? Тэдгээрт чухам юу гэж бичсэн байна вэ? Тэр үед Тува нар Монгол улстай нэгдэхэд чухам юу саад болсон юм бэ?

-Тувагийн хошуудаас ирүүлж байсан эдгээр хүсэлтүүд манай улсын ГХЯ-ны архивт бүрэн бүтнээрээ хадгалагдаж байна. Тэдгээрт Тува нар угаасаа хүн ам цөөн, улс орныг авч явах эрдэм чадалтай хүн үгүй агаад хөрөнгө чинээ ядмаг тул ард олноос албан татвар, гааль түрээс тусгаарлан авах боловч хаа ч хүрэлцэхгүй тул бие даасан тусгай улс болоход үлэмж бэрхшээлтэй байгааг дурьдаад шашин угсаа нэгтэй ах дүү Монгол улстай нэгдэх чин хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байлаа.

Тува Монголтой нэгдэхэд тухайн үеийн олон улсын байдал, Тува дахь оросын эрх ашиг хоёр хамгийн гол саад болсон гэдгийг дотоод гадаадын олон эрдэмтэн хүлээн зөвшөөрдөг. 1924 оны 5 дугаар сард Бээжинд гарын үсэг зурсан Зөвлөлт-Хятадын хэлэлцээгээр ЗХУ Гадаад Монголыг Дундад Иргэн улсын бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн тул Монгол улс Хятадын захиргаанд орж болзошгүй улмаас Тувагийн тусгаар байдлыг хадгалах, нөлөөгөө бэхжүүлэх замаар Орос, Монголын /өргөн утгаар Хятадын/ хооронд халхавч болгон үлдээх хэрэгтэй байлаа. Нөгөө талаар Тувад суурьшсан 11 мянга гаруй орос иргэд Тувагийн улс төр, эдийн засгийн амьдралд ихээхэн үүрэг нөлөөтэй болсон байжээ.

-Монгол улс хэрхэн Тагна Туваг хүлээн зөвшөөрсөн бэ? Энэхүү шийдвэр гарахад гадны оролцоо хэр зэрэг байсан бэ?

-Монгол-Тувагийн харилцааны гуравдахь үе шат Монгол улс Туваг хүлээн зөвшөөрч албан ёсны харилцаа тогтоосон 1926-1944 оныг хамаарна. Хэмчигийн бослогын дараа Монголын эрх баригчдын дунд Туваг нэгтгэн авах асуудал бол Зөвлөлтийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарах амаргүй бөгөөд бараг үл биелэх, осолтой зүйл хэмээн ойлгох хандлага нэлээд нэмэгдэж ирсэн. Үнэхээр ч Коминтерн болон Зөвлөлтөөс Монголд сууж байсан элч, төлөөлөгчид МАХН-ын ТХ, Засгийн газарт Тагна Туваг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд багагүй хүч чармайлт, дарамт үзүүлж байсан юм. Монгол дахь Зөвлөлтийн элчин төлөөлөгч П.М. Никифоров 1926 онд хийсэн ажлынхаа тайланд "Бид /Никифоров, Амгаев/ монголчуудыг нармай Монголын үзлээс татгалзах хэрэгтэй гэдгийг тулгасан. Дээд удирдлага нь үүнд ихээхэн

хойрго хандсан бөгөөд хөдөөгийнхөн уриалгахан хүлээн авав. Нааштай үр дүн 11 дүгээр сард /1925/ гарч Улаанбаатар Урианхайн засгийн газрыг хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн юм" хэмээн бичсэн байв.

Мөн түүнчлэн Тувагийн Засгийн газраас удаа дараа албан ёсны харилцаа тогтоох талаар ирүүлж байсан хүсэлт эрмэлзлийг харгалзан Монгол улсын нам төрийн дээд байгууллагууд Тувагийн засгийн газрыг хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн билээ. 1926 оны 8 дугаар сарын 16-нд Улаанбаатар хотноо Монгол ба Тагна Тува хоёрын хоорондох Найрамдлын гэрээ бичигт гарын үсэг зуржээ. 12 зүйлтэй энэ гэрээнд харилцан бүрэн эрх барих төлөөлөгч солилцох, хилийн комисс байгуулж хил хязгаарыг тодорхой болгох, хил хязгаарыг хатуу чанд сахих, харилцан худалдаа хийх, утсан ба шуудан харилцаа тогтоох, эдийн засаг соёлын холбоог бэхжүүлэхэд онцгой анхаарах зэрэг асуудал тусгагдсан байна.

Монгол улс Тагна Тувагийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн явдалд Зөвлөлтийн зарим удирдагч шүүмжлэлтэй хандаж байлаа. Тухайлбал, Зөвлөлтийн Гадаад Хэргийн Комиссарын орлогч Л.М. Карахан олон улсын эрх зүйн талаас Монгол, Тувагийн хооронд албан ёсны харилцаа тогтоосон явдлыг хэрхэн үзэх талаар бичихдээ "Зөвлөлт-Хятадын хооронд байгуулсан хэлэлцээрийн үр дүнд Монгол нь автономит өргөн эрхтэй болсон тул Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх явдал бараг боломжгүй байхад Монголд Туваг хүлээн зөвшөөрөх санал тавих нь бүр ч хачирхалтай. Ингэснээр Хятадын дургүйцлийг төрүүлэхийн сацуу төр засаг нь бэхжиж чадаагүй, олон нийтийн байгууллага, зохион байгуулалттай аж ахуй, бичиг үсэг ч байхгүй Тагна Тувад Хятад улс нэн даруй анхаарах ёстойг сануулахад хүргэнэ. Тувагийн талаарх манай бодлого Тувагийн төр ёсыг бэхжүүлэн Хятадтай хэлэлцээ хийж, тодорхой хэмжээнд автономит эрхийг шаардах түвшинд хүргэхэд чиглэх ёстой. Монгол, Тува харилцан тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрөх явдал ямар ч шаардлагагүй бөгөөд Монголд ч Тувад ч бодитой ач холбогдолгүй. Харин Монголчууд улс төрийн талаар Тувад түрэмгий бодлого явуулахын оронд Тувагийн нийгмийг зохион байгуулах, ардын нам, эвлэлийн ажил, олон түмнийг соён гэгээрүүлэх, худалдаа хөгжүүлэхэд тусалбал зохилтой" гэжээ.

*-Монгол-Тувагийн харилцааны хамгийн эмзэг, хамгийн сонирхол татсан нэг асуудал бол яах аргагүй хил хязгаарын асуудал. Та Монгол-Тувагийн хил тогтоосон түүхээс сонин зүйл хэлэх байх **даа?***

-Олон зуун жил нэгэн улсын бүрэлдэхүүнд хамт байж, хүн ард нь айл хөрш аж төрж байсан Монгол, Тувагийн хооронд хилийн

тодорхой шугам, тогтсон хатуу зааг байсангүй. Гэхдээ түүхийн сурвалж бичиг, судалгааны зохиолуудаас үзэхэд тува нарын Тагна уулаас урагш зөвшөөрөлгүй гарч явахыг чанд хориглож байлаа. Тийм учраас язгуурын нутаг Саяны нуруу ба Тагна уулын хооронд байсан бөгөөд Манжийн засаг захиргаа ч тува нарыг Тагна уулаас урагш зөвшөөрөлгүй гарч явахыг чанд хориглож байлаа. Тийм ч учраас манжийн үеийн газрын зурагт Монгол, Тувагийн хоорондын нутаг бэлчээрийн заагийг Тагна уулын оройгоор заан тэмдэглэсэн ажээ. Гагцхүү үүнийг түүхэн хил хэмээн авч үзсэн юм.

1926 оны Найрамдлын гэрээний 6 дугаар зүйлд заасны дагуу 1926 оны 10 дугаар сард Монгол Улсын Засгийн Газар, МАХН-ын Төв Хорооноос БНМАУ, БНТТУ-ын хил хязгаарыг шинэчлэн тогтоох, хилийн асуудлыг цэгцлэх Төв комисс байгуулжээ. Ийнхүү хил тогтоох комиссыг хилийн асуудлыг цэгцлэх гэсэн тодотголтойгоор яаравчлан байгуулсан нь хоёр орны хил дээр элдэв хэрэг зөрчил улам бүр нэмэгдэж байсантай холбоотой юм. Тухайлбал 1928 оны 10 дугаар сарын 13 нд Монголын ГЯЯ-аас Тувагийн элчин төлөөлөгч Анандад 200-аад Тува хүн бүлэглэн буу зэвсэг хэрэглэн дураар хил давж, манай улсын Чандмань, Төгсбуянт хошууны нутагт нэвтрэн орж тарвага агнах, өвс бэлчээрийг сүйтгэх, өвөлжөө бууцыг засаж суурьшихыг завдан ашиг шимийг ашиглаж, уул хошууны олон ардын аж амьдрлыг алдагдуулахад хүрсэн нь гэрээ ба найрамдалд харшилтай тул харьяат иргэдээ даруй татан авахыг шаардаж байв. Энэ мэтээр газар нутгийн төлөө тэмцэл хил заагийг эцэслэн тогтоох хүртэл тасралтгүй үргэлжилсэн юм.

Хоёр тал нэлээд бэлтгэл хийсний эцэст 1930 оноос хил тогтоох яриа хэлэлцээ хийж эхэлсэн бөгөөд 1944 он хүртэл нийтдээ /1930,1932, 1934, 1940/ 4 удаа хилийн асуудлыг хэлэлцсэн боловч хоёр тал олигтой үр дүнд хүрч чадаагүй.

1930 оны 3 дугаар сарын 16 нд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Элдэв-Очир, Ө.Бадрах, ТАХН-ын Төв Хороны ерөнхий нарийн бичгийн дарга С.Тока нар хилийн комисс байгуулах тухай протоколд гарын үсэг зуржээ. Уг Протоколын гуравдугаар зүйлд "манай хоёр орон ардын хувьсгалт намын удирдлагаар социализм байгуулж буй тул хилийн асуудлыг шашин-үндэсний заншил, хуучин манжийн хилийн зарчмаар биш, харин ард олон, тэдний аж ахуйг соёлтой хөгжүүлэх зарчим баримталбал зохистой" гэсэн заалт оруулсан нь Монголын хувьд түүхэн хилээ баримтлах гэсэн байр сууринаас ухарсан эхний алхам болсон төдийгүй маргаантай газруудад тува нар олноороо ирж суурьших үндэс суурийг тавьсан бололтой.

Үүний дараа хоёр орны засгийн газраас томилогдсон хамтарсан комисс шинээр хил тогтоох асуудлаар 2 жил гаруй хэлэлцсэн боловч тохиролцоонд хүрч чадаагүй. Хэлэлцээн дээр Монголын тал хуучин хилийн шугамаар буюу Тагнын нуруугаар, Тувагийн төлөөлөгчид дээр дурдсан протоколын дагуу монголын хилийн харуул байрлаж байсан газраар шинээр хил тогтоох санал тавьсан тул хоёр тал мухардалд орсон юм.

1932 оны эхээр Монгол-Тувагийн хилийн комиссын ажил дахин сэргэж, хоёр талын хүсэлтээр хил тогтоох ажилд Зөвлөлтийн мэргэжилтнүүд оролцон анх удаа хилийн заагийг урьдчилсан байдлаар тогтоосон ажээ. Монголын тал энэхүү хилийн шугамаас хойш орших 3550 км^2 нутаг дэвсгэр маргаантай хэмээн протоколд гарын үсэг зурахаас татгалзаж байлаа. Харин 1932 оны 7 дугаар сард П. Гэндэн Ерөнхий сайд болсныхоо дараа БНМАУ, БНТАУ-ын хоорондын хилийн зөрөлдөөн бүхий асуудлыг таслан шийдвэрлэсэн 1, 2, 3 дугаар хурлын тогтоол нь үндсэндээ зүйтэй болсон тул соёрхон батлах тухай Засгийн Газрын 8 дугаар тогтоолд гарын үсэг зуржээ. Ингэснээр Монгол-Тувагийн хил Тагнын нуруугаар биш, харин түүнээс 10-20 км дотогшилсон ба энэ нь манай улс хилийн зааг нутгаа, түүний дотор Давст уулыг Тувад өгсөн анхны шийдвэр болсон ажээ. 1932 оны хилийн Протоколыг БНМАУ-ын Улсын Бага Хурал ард түмний эрх ашигт үл нийцсэн хэмээн үзэж батлаагүй.

1934 онд Монгол, Тувагийн Засгийн газрууд хилийн хэлэлцээгээ сэргээн Цагаан толгой хэмээх газраас эхлэн Мөнхсардиг хэмээх газар хүртэл хил тогтоох асуудлыг хэлэлцсэн боловч мөн л эцсийн шийдвэрт хүрч чадаагүй.

1940 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо БНМАУ-ын Засгийн Газрын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд маршал Х.Чойбалсан Тувагийн элчин төлөөлөгч Намсрайтай хилийн асуудлаар 4 дэх хэлэлцээ явуулах талаар хэлэлцээд дор дурдсан зүйлүүдийг тохиролцжээ. Монгол Ард Улс ба Тува Ард улсын хилийн шугамыг тодорхойлохдоо:

а/ Монгол, Тува хоёр улсын хилийн шугамын тухай хуучин түүхт материалыг авлага болгон хэрэглэх

б/ 1932 оны хилийн комиссуудын материалыг яг баримтлахгүй бөгөөд тэрхүү материалыг хилийн шугамыг тодотгох ажилд ашиглана гэжээ.

Монголын хилийн комиссын дарга С.Янжмаа 1940 оны 8 дугаар сарын 11-ны өдөр хэлэлцээ явагдахад Хандгайтад хүрэлцэн очиж Тувагийн Засгийн Газрын комиссын дарга Бадраатай хоёр засгийн

газраас олгосон итгэмжлэх бичгийг солилцон, 12-ны өдөр анхдугаар хамтарсан хурлыг зарлан хуралдуулжээ. Энэ удаагийн хэлэлцээгээр газар орны байдлыг газар дээр нь очиж танилцан, зарим үед түүхэн материалыг тулгаж үзэн, нэлээд хэмжээний газарт санал нийлж байсан бөгөөд зарим санал зөрөлдөөнтэй газрын асуудлыг сайтар нягтлан судалсны үндсэн дахин хэлэлцэхээр тохиролцжээ.

1944 оны 10 дугаар сард Тува ЗХУ-д нэгдсэнээр хилийн асуудал Монгол-Зөвлөлтийн хоорондын асуудал болсон билээ. Энэ үед ЗХУ-ын хилийн цэрэг Автономит мужийн хэсэг дэх Монгол-Зөвлөлтийн хилийг 1932 оны Монгол-Тувагийн хилийн комиссын тогтоосон шугамын дагуу хамгаалалтдаа авчээ.

Үүнээс хойш 1945, 1947 онуудад монголын тал хил тогтоох асуудлыг нэн даруй щийдвэрлэх хүсэлтээ Зөвлөлтийн Засгийн Газарт тавьж байв. Харин 1957 онд Зөвлөлтийн тал Монгол улс ба автномит Тува мужийн хоорондох хилийг зааглан тогтоох хэлэлцээрийг сэргээх саналыг манайд тавьжээ. Энэ асуудлыг МАХН-ын Улс Төрийн Товчоо 1957 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр авч хэлэлцээд "Хилийн шугамыг тодруулан тогтоох хэлэлцээг явуулахдаа түүхт материалыг голчлон үндэс болгохоос гадна ард түмний одоогийн амьдралын шаардлагыг харгалзан гүйцэтгэх" чиглэл өгчээ. Мөн өдөр СнЗ-ийн 458 дугаар тогтоолоор хилийн хэлэлцээр хийх Засгийн газрын төлөөлөгчдийг баталж, даргаар нь ГЯЯ-ны сайд С.Аварзэдийг томилжээ. Хэлэлцээр Монгол-Тувагийн 1932, 1934 оны гэрээг түүхт материал гэж үзэх эсэхээс эхлээд маргаантай, сунжрах төлөвтэй болсон юм. Хилийн комиссын Зөвлөлтийн талыг ЗХУ-аас манайд сууж байсан элчин сайд В.М. Молотов толгойлж байсан юм. Тэрбээр хилийн асуудлыг 1932 оны протоколын дагуу шийдэх байр суурийг тууштай баримталж байв. 1958 оны эхээр ЗХУКН-ын Төв Хорооноос хилийн асуудлыг 1932 оны Протоколын дагуу шийдэхийг шаардсан Мэдэгдэх бичгийг монголын талд гардуулан хүчтэй шахалт үзүүлсний дараа хилийн хэлэлцээ үндсэндээ Зөвлөлтийн саналын дагуу явагдаж, 1932 онд тогтоосон хилийн шугамыг бага зэрэг засвар оруулах замаар Монгол-Зөвлөлтийн Тувагийн хэсэг дэх хил тогтоогдсон байна.

Эцэст хэлэхэд Монгол Улсын хувьд хоёр хөрштэйгээ хилийн гэрээ байгуулж хил хязгаараа хуульчлан баталгаажуулсан нь том ололт мөн боловч үүндээ тайвшран хилийн түүхээ судлах ажлыг хэрхэвч сулруулж болохгүйгээс гадна хилийн асуудалд нэн нягт нямбай хандах хэрэгтэй юм.

Ярилцсан Г.Дагважамц